

СПОРТЫН ТАЙЛБАРЫН ХӨГЖИЛ МОНГОЛД

С.Ганцэцэг*, Б.Батзаяа**

*МУБИС-ийн БТС-ийн багш, доктор (Ph.D), дэд профессор

**Хөл бөмбөгийн тайлбарлагч, нийтлэлч, сэтгүүл зүйн магистр (МА)

Түлхүүр үг: спортын тайлбар, спортын тайлбарын хөгжил, спортын тайлбарлагчийн төрөл, мэргэшсэн тайлбарлагч

Сэтгүүлзүйн салбарт спорт томоохон байр суурь эзлээд багагүй хугацаа өнгөрлөө. Энэ хугацаанд спортын тайлбарлагчдын эрэлт хэрэгцээ өсч, телевиз бүр спортын албатай, спортын сурвалжлагч, тайлбарлагчтай болж байна.

Манай улсад спортын тайлбарын төрөл үндэсний спортоор хязгаарлагдаж байсан бол хэвлэл мэдээллийн хэрэгсэл тэр дундаа радио, телевизийн эрчимтэй хөгжил спортын тайлбарыг шинэ түвшинд авчирсан юм. Радио нь дүрсгүй ч дуу чимээгээр дамжуулдаг, шуурхай хямд учраас хэвлэл мэдээллийн хэрэгслийн спортын тайлбарлагчдын ажлын анхны гараа байлаа. XX зууны дунд үеэс үндэсний баяр наадмыг эх орны өнцөг булан бүрт суух ард иргэддээ радиогоор дамжуулан шууд тайлбарлан хүргэж эхэлсэн байдаг. “Үнээ саалгадаггүй хоёр Мөнх” радиогийн тайлбарын хоногшиж үлдсэн үйл явдал байлаа. Нэг мэдээллийн хэрэгсэл буюу радиогоор шууд тайлбар хүргэх нь улс орон даяараа спортын үг хэллэгийг

мэргэжлийн тайлбарлагчийн тусламжтай мэдэж авах, эх орны тамирчдынхаа нэр ус, аль нутаг илүү бөхтэй гэх зэрэг нэмэлт мэдээллүүдийг мэдэх боломж бүрдүүлж байснаараа олон давуу талтай байсан.

Спортын тайлбарлагч гэдэг нь шууд тоглолтын үеэр тухайн цаг хугацаанд тайлбарлан, тоглолтын дүрсэд дуу оруулахыг хэлдэг. Спортын тайлбарлагчдыг хоёр төрөлд хувааж үздэг.

1. Main/play-by-play commentator буюу газар дээрээс нь тайлбарладаг үндсэн тайлбарлагч. Үндсэн тайлбарлагч нь ихэвчлэн спортын хурдтай агшин, үйл явдлыг тухайн хэмнэлд нь орж тоглолтын явцыг тайлбарлан хүргэдэг.
2. Analyst/color commentator буюу мэргэжлийн аналит (шинжээч), тайлбарлагч. Мэргэжлийн аналит, тайлбарлагч нь статистик, баг, тамирчид, тактикт дүн шинжилгээ хийж мэдээлэл хүргэдэг. Зарим онцгой тохиолдол байдаг ч голдуу хөлбөмбөгийн тоглогч, дасгалжуулагч байсан хүмүүс мэргэжлийн аналит тайлбарлагчийн ажлыг хийдэг.

Үндсэн тайлбарлагч нь тоглолтын хэмнэлд орж, өөрөө тамирчин шиг сэтгэл хөдлөл, үг хэллэгээр үзэгч, сонсогчдыг байлдан дагуулдаг. Харин мэргэжлийн, аналит тайлбарлагч тоглолтын бүтэц, үйл явдал гарааны болон сэлгээний тоглогчдын давуу болон сул талыг ярьж, түүхэн мэдээлэл, санаа, жишээг гаргаж тавьдаг.

1 1979 онд АНУ-д “ESPN” спортын анхны төрөлжсөн суваг бий болсноор спортын тайлбарлагч, аналитууд төрөлжсөн телевизэд тайлбарлагч хийх нь элбэг болсон. Билл Расмуссэн, хүү Скотт Расмуссэнийхаа хамтаар “ESPN”-ийг байгуулснаар өдгөө спортын 12 үндсэн сувагтай болтлоо хүрээгээ тэлж чаджээ. Спортын тэмцээн уралдааныг тогтмол цацах болсноор тайлбарлагч, аналит, спор-тын сэтгүүлчдийн ажлын байрыг олноор бий болгож 1980-аад онд тайлбарлагчдын тоо эрс өссөн байдаг. Байгуулагдснаасаа арван жилийн дараа буюу 1989 онд “ESPN” телевиз олон улсын сувагтай болсноор Америк, Ази тивд өөрсдийн телевизийн байр, тусгай сувагтай болжээ. Харин хөл бөмбөгийн хамгийн шилдэг тайлбар-лагчид нь хөл бөмбөгийн хамгийн том лигүүдтэй Европ тивд байлаа. 1971 оноос хойш Английн “BBC” сувгийн радиогийн тайлбар-лагчаар ажиллаж эхэлсэн Жон Мотсон, 1500-аас дээш тоглолт тайлбарласан хамгийн алдартай нь байсан юм. Түүний араас сул үг ихээр ашигладаг Энди Грэй, Мартин Тэйлор нар хөл бөмбөгийн шилдэг тайлбарлагчдын залгамж халаа болсон. Тайлбарлагч бүрт өөрийн гэсэн онцлог, өнгө төрх, сэтгэл хөдлөлөө илэрхийлэх чадвар, үг сонголтын ялгаа байсан бөгөөд Жон

Мотсон 1990-ээд оноос хойш компьютер тоглоомонд өөрийн дуу хоолойг буулгах болсон юм. Энди Грэй хэдий шилдэг тайлбарлагч боловч 2011 онд нэгэн ноцтой алдаа гаргасан. Английн Премьер лигийн тоглолтын үеэр микрофоноо хаалгүйгээр эмэгтэй шүүгч Саян Массиг “Түүнд итгэж болох уу? Эмэгтэй шугамын шүүгч. Эмэгтэйчүүд отон тоглолтыг мэдэхгүй” гэж хэлэхэд түүний хамтрагч Ричард Кис “Мэдээж тэр чадахгүй” гэж хэлээд хамтдаа “Sky sports”-оос халагдаж байсан түүхтэй.

Манай хойд хөрш ЗХУ буюу одоогийн ОХУ-ын спортын тайлбарлагчдын түүх бидэнд илүү ойр. Алдарт тайлбарлагч Николай Озеровын “Сурвалжлагаа сурвалжилсан минь” номноос иш татвал “Хамгийн гол нь тайлбарлагч хүн үргэлж суралцаж байх ёстой. Өөрийнхөө мэргэжлийг дандаа дээшлүүлж шүүлт, тоглолтын дүрэм зэргийг сурч эзэмших ёстой болдог юм. Түүнээс гадна дуу хоолой, дуудлагаа хүртэл нарийн болгон, уран уншлагаар хүртэл хичээллэх хэрэгтэй болдог. Тайлбарлагч хүн маш их анхааралтай байж ямар ч нөхцөлд тэвдэхгүй, тэвчээртэй байх шаардлагатай байдаг юм. Яагаад гэвэл радио сонсогчид, телевиз үзэгчид аль нь ч гэсэн бидний алдааг уучилдаггүй. Сүүлийн үед хэн нэг хүний тоомсоргүй хандлагаас болж, спортын тайлбарлагчийн тухай барагтайхан ярих болов. Яагаад энэ вэ? Энэ асуултад хариулахад хялбархан ч юм шиг санагддаг юм. Яагаад хялбар вэ гэхээр, үнэхээр ч тайлбарлагчид ярихдаа алдаж, ярихдаа будилж, ямар ч сургуулилалтгүй ирж, сурвалжлагаа бэлтгэлгүй эхэлдэгт байгаа юм. Хамгийн гомдууштай нь тэд үгийг буруу дуудаж, эв хавгүй юм ярьдаг учраас хурц, шударга шүүмжлэлд өртөж

байдаг”¹ гэж тайлбарлагчийн ажлын онцлогийн тухай хэлсэн байдаг.

Манай улсын хувьд үндэсний спорт-эрийн гурван наадмыг тайлбарлах нь тайлбарлагчдын анхдагч түүхээ байв. Монгол улсын арслан, тайлбарлагч Ц.Бадамсэрээжид гуай Монголын тайлбарлагчдын түүхэнд шинэ хуудсыг нээсэн гавьяатай. Түүний тухай Ц.Галбадрахын “Монголын цуут” номонд “1956 оны улсын их баяр наадмын үндэсний бөхийн барилдааныг тайлбарласнаас хойш бөхийн тайлбарлагчаар 35 жил ажиллахдаа хүчит бөхчүүдийн барилдааныг нүдэнд харагдаж, сэтгэлд дүрслэгдтэл уран яруу тайлбарлаж бөхийн спортыг сурталчлах, хөгжүүлэхэд их хувь нэмэр оруулж олны талархал хүлээсэн.

Наадам ид дундаа. Говь нутгийн эгэл малчин ард Цэнддоо гуайнх улсын наадмын хүчит бөхийн барилдааныг радиогоороо сонсоод л. “Циркийн Дамдин гарлаа... давлаа”, “Дархан аварга Мөнхбат, Баянмөнх, аварга Бээжин, Өмнөговийн хүчит арслан Дэмүүл нар даваад туг тойрч явна”... гэжээ. Тайлбарлагч Ц.Бадамсэрээжид арслангийн дуу эх орон даяар ийн хүнгэнэхэд хаяаг нь ханын тэхий дундаас дээш гаргаж шуусан гэрийн сүүдэрт хэвтэж байсан хүүгийн сэтгэл өөрийн эрхгүй хөдлөх. Тэрхүү аварга бөхчүүдийн дүр төрхийг тайлбарлагчийн дуу хоолойны өнгө аясаар дамжуулан сэтгэлдээ ургуулан төсөөлж бодоод л...”² хэмээн өгүүлжээ.

Ц.Бадамсэрээжид арслангийн араас залгамж халаа болсон шилдэг тайлбарлагчид төрөн гарсан.

1965-1967 онд Монголын Үндэсний Телевиз байгуулах бэлтгэл ажил эхэлж, албан ёсны нээлтээ хийгээгүй байсан ч 1967 оны долоодугаар сарын 10-нд Монголын

зурагт радиогийн дэлгэц монгол айлд анх гэрэлтэн асч туршилтын нэвтрүүлэг хийв. Туршилтын журмаар явуулсан анхны энэ нэвтрүүлгээр монгол ардын хувьсгалын 46 жилийн ойн баярын угталтын хурал, концертыг улсын дуурь бүжгийн театраас шууд дамжуулан үзүүлсэн юм. Энэ өдрийн нэвтрүүлэг 18.00-20.45 цаг хүртэл үргэлжилжээ. Туршилтын дараагийн нэвтрүүлэг нь долоодугаар сарын 11-ний өглөө 8 цаг 30 минутаас Сүхбаатарын талбайгаас шууд дамжуулсан ардын хувьсгалын 46 жилийн ойн баярын жагсаал, мөн 15.00 цагаас төв цэнгэлдэх хүрээлэнгээс шууд нэвтрүүлсэн хүчит бөхийн барилдаан юм. Бөхийн барилдааныг 12-ны өдөр ч бүрэн хэмжээгээр үзүүлжээ.

Наадмын концертыг телевизээр дамжуулахад театрынхан “хүмүүс үзэхээ больчихно” гэж дургүйцэж байсан бол АИХ-ын дарга Ж.Самбуу гуай өмнөх микрофоноо нээлттэй байгааг мэдэлгүй Г.Дэмүүлийг “мэх хийдэггүй золиг байна” гэх мэтээр ярьсан нь хүмүүст сонсогдсон гэж телевизийн ахмадууд дурссан байдаг.

Телевиз орон даяар цацагдах болсноор радиогийн тайлбарлагч дээр телевизийн тайлбарлагч нэмэгдэж, дүрстэйгээ уялдуулан тайлбарлаж, сонсогч олон үзэгч олны эгнээнд шилжиж эхэлсэн гэдэг. Радиогийн тайлбарын уран яруу үг хэллэгийг сонсогчид төсөөлөн суудаг байсан бол телевизээр дүрсийг нь харж, тайлбарлуулах болсон юм.

Ц.Бадамсэрээжид арслангийн дараа Монгол Улсын начин Ш.Чанарав, А.Ганбаатар нарын шилдэг тайлбарлагчид Монгол үндэсний бөхийн тайлбарлагч хийж, үзэгч олондоо өөрсдийн дуу хоолой, өнгө төрхийг үлдээсэн юм. “1993 он урган гарав аа.

Энэ он Монголын спортын түүхэнд бас нэг шинэ шан татаж, бөхчүүдийн нутаг ус, үүх түүх, цол гуншин, гавьяа шагналыг цээжээрээ мэддэг "амьд" лавлах болсон тайлбарлагч, улсын начин Агвааны Ганбаатар соёлын гавьяат зүтгэлтэн цолыг Монголын тамирчдаас анх хүртсэн билээ. Түүний дуу, хоолойны өнгө цаанаа л нүнжигтэй, тослог. Үл ялиг марзагнал, бөхчүүдийн тухай жаахан давстай яриа, хүнгэнэсэн сайхан дууг нь сонссон шигээ бөх харах үнэнхүү бахтай" гэж спортын сэтгүүлч, нийтлэлч Ц.Галбадрах дурссан байдаг.

Монгол улсын начин Ш.Чанарав гуайн тайлбарын мэдрэмж буюу тайлбарлагч хүний барилдааныг харах торгон агшнаас дурдвал, "...Сумьяабазар зааны нэг гар сул яваад байна даа. Ингэж байж гар ачуулчихвий дээ... За, гар ачлаа. Гар ачаанд унахгүй гэж бодож явж буруутах шиг боллоо. Улсын заан Агваансамдангийн Сүхбат долоо давлаа..."

"...Цэрэнтогтох аварга хөл л авах гээд байх шиг... Ойрын барилдаанд хөл аваагүй дээ. Залуу заан Бат-Эрдэнийг хонгодож дайраад давчихаж болмоор санагдаад байгаа юм болов уу..." гэж 1987 оны наадмын шөвгийн дөрвийг тайлбарлаж байсан нь ой тойнд минь хамгийн анх үлдсэн бөхийн тайлбар. Үнэхээр төд удалгүй Цэрэнтогтох аварга залуухан заан Б.Бат-Эрдэнийг хонгодон дайрч давж билээ" гэж www.news.mn сайтын сэтгүүлч Р.Гэгээ тэмдэглэн үлдээжээ.

Орчин үеийн спортын хувьд 1980 онд Москвагийн Зуны Олимпийн наадмыг шууд дамжуулснаас хойш бусад төрлийн спортын тайлбарыг сонсож эхэлсэн. Тухайн үеийн Зөвлөлтийн "ОРТ" сувгаар хөл бөмбөг, хоккейн тэмцээнийг үзүүлэх

болсноор монголчууд гадны спортын тайлбарлагчидтай танилцсан юм. 1990 оноос зах зээлийн нийгэмд шилжсэнээр арилжааны телевизүүд үүд хаалгаа нээв. 1972 онд байгуулагдсан "Телекино" үйлдвэрийн бааз сууринд түшиглэн нийслэл хотын захиргааны мэдлийн "Улаанбаатар" телевизийг 1992 онд байгуулжээ. "Улаанбаатар" телевиз нь хотын захиргаанаас санхүүжиж, "Монгол" телевизийн сувгаар долоо хоногт нэг удаа нэвтрүүлэг дамжуулдаг байв. 1996 онд Монголын анхны арилжааны телевиз "25-р суваг" байгуулагдсан. Мөн онд Америкийн хөрөнгө оруулалттай "Eagle" телевиз үйл ажиллагаагаа эхэлжээ. Эдгээр телевизүүд нээгдснээр хөл бөмбөг, сагсан бөмбөгийн тэмцээнийг бичлэгээр үзүүлж, тайлбарлагчид ажиллаж байв. Монголын Үндэсний Телевизийн сэтгүүлч Н.Тамирын бэлтгэн хүргэдэг Монголын тамирчдын бичлэг, хөлбөмбөгийн олон улсын тоглолтууд шинэ спорт, шинэ тайлбар байв. Н.Тамирын сагсанбөмбөгийн тайлбарын дундуур "Маикл Жордан агаарт 9 секунд тогтдог" гэдэг үгэнд үзэгчид үнэмшиж, улс орон даяар энэ тухай хөөрөлддөг байлаа.

2002 онд Л.Цагаандалай эрхлэгчтэй "Чандмань" студи хөлбөмбөгийн дэлхийн аваргын сүүлийн тоглолтуудыг Оросын телевизээс шууд дамжуулан үзүүлсэн нь монгол тайлбартайгаар цацагдсан анхны хөлбөмбөгийн тоглолт байсан юм. Тухайн үед Д.Баярсайхан, Г.Отгонжаргал, Б.Эрдэнэболд нар тайлбарлагчаар ажилласан. Харин 2004 онд "ABU" буюу Азийн өргөн нэвтрүүлгийн холбооноос Зуны Олимпийн наадмыг шууд дамжуулах эрхийг манай улсад өгснөөр "ТВ5" телевиз албан ёсоор анх удаа спортын том арга хэмжээг шууд дамжуулсан.

Спортын тайлбарлагчийн салбар төдийлөн хөгжөөгүй байсан учраас спорт холбоодын шүүгч, дасгалжуулагч, тамирчид телевизийн тайлбарт ажилласан. Чөлөөт бөхийг Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, гавьяат тамирчин З.Ойдов, сагсан бөмбөгийг гавьяат дасгалжуулагч Ц.Цэвэрбал, Б.Дамба, хөл бөмбөгийг дасгалжуулагч Л.Доржжав, И.Отгобаяр, тамирчин Б.Батзаяа нар тайлбарлан хүргэж байлаа. Энэ үеэс Монголын телевизийн салбарт спортын тайлбарлагч гэдэг шинэ мэргэшил гарч ирсэн юм. Үүний дараагаар дэлхийн хамгийн том спортын арга хэмжээ 2006 оны хөл бөмбөгийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээний эрхийг “С1”, “ТВ5” телевизүүд авч Б.Батзаяа, “Таван цагариг” сонины сэтгүүлч Г.Баярсайхан, Ж.Батмөнх, Б.Баяржаргал, олон улсын шүүгч М.Батболд нар тайлбарлажээ. 2006-2007оны Европын хөл бөмбөгийн аваргуудын лигийн тэмцээнийг шууд дамжуулах эрхийг “С1” телевиз авснаар удаан хугацаанд үргэлжлэх тэмцээнийг тайлбарлах байнгын тайлбарлагч ажиллах болов. Тухайн үед “ТВ9” телевизэд Э.Балжинням тайлбарлагчаар ажиллах болсон бөгөөд өөрийнхөө тайлбарын онцлогийг “Миний тайл-барын онцлог нь хөдөө малаа хотлуулж буй малчин, ажлаа тараад ирж буй хүмүүс, хичээлээ тараад ирсэн жаалхүү нарт зориулж тайлбарладаг юм. Би тактик ярьдаггүй, тэр Жозе Моуриньо 11 залуустаа юу хэлээд гаргаж байгааг нь энд хэн мэдэх билээ. Монголчууд бид хүний түүх намтар, цол гуншинг сонсох дуртай ард түмэн. Тиймээс би монгол хэв маягийн тайлбар хүргэхийг л эрмэлздэг. Хүн харснаа л ярих нь зөв. Намайг хүн Пелег ярь гэвэл домог энэ

тэр гээд л зогсоно. Харин Жеррардын тухай бол хүүрнэн өгүүлнэ” гэжээ.

“Спорт сонирхогч, шүтэн бишрэгч гэдэг бол /ийм төрлийн нийтлэл нэвтрүүлгийн хамгийн үнэнч хүлээн авагчид нь/ спортынхоо талаар гүнзгий мэдлэгтэй байдаг тул мэдээлэл дамжуулахдаа тамирчны овог нэрээс эхлээд холбогдох бүхий л баримтыг нарийн нягтлан ашиглах нь чухал. Спортын мэдээлэлд тоглолтын оноо, үзүүлэлт, багууд болон тамирчдын нэр, спортын төрөл, ангилал, тоглолт хэзээ хаана болсон, тоглолтын хамгийн анхаарал татахуйц хэсэг, тоглолтоос хасагдсан тоглогчид, ямар зэрэглэлийн тоглолт болох, оноог хэрхэн авсан, тоглолтын дүн багийн амжилтанд хэр-хэн нөлөөлөх, тоглолтын стратеги, үзэгчдийн тоо, тэдний биеэ авч яваа байдал, тоглолтын талаарх нэмэлт тоо баримт, бэртэж гэмтсэн тоглогч бий эсэх, хожигдсон болон хожсон багийн сэтгэл хөдлөл, тоглолт үргэлжилсэн хугацаа, дээд амжилтыг эвдсэн эсэх, тоглолтын дараах баг тамирчдыг сэтгэгдэл зэргийг тусгасан байж бүрэн төгс мэдээлэл өгнө”³.

Одоогоор “Sansar HD Premier Sport”, “Sports box” гэсэн спортын хоёр телевиз хөл бөмбөгийн Английн Премьер лиг, Италийн Сери А, Аваргуудын лиг, Либертадоресын цомыг шууд дамжуулж байгаа бол “НТВ” телевиз Германы Бүндэс лигийг шууд дамжуулж байна. 2004 онд “ТВ5” телевиз Афины зуны олимпийг шууд дамжуулсны дараа “С1” телевиз дэлхийн аваргыг 120 сая төгрөгөөр авсан нь олон улсын тендэрт өрсөлдсөн анхны тохиолдол байлаа. Ийм өндөр хэмжээний мөнгө гаргасан телевиз шууд нэвтрүүлэг, тайлбарлагчийн шаардлагыг өндөр болгосон нь тухайн

үед чухал нөлөө үзүүлж байлаа. Хөтлөгч тоглолтын өмнө зочинтой ярилцаж, тоглолтыг тайлбарлагч тайлбарлан хүргэх нь өмнө нь манай улсын хэмжээнд байгаагүй. Хөтлөгч, тайлбарлагч гэдэг тусдаа мэргэшил гэдгийн ялгааг тухайн үед тод харуулсан. Үүнээс хойш үндэсний спортын төрлөөс гадна бусад спортын тайлбарлагчид төрөн гарч ирэх боломж, үүд хаалга нээгдсэн юм.

2007 оны аваргуудын лигийн тэмцээний хөтлөгч Э.Амарсайхан, тайлбарлагч

Б.Батзаяа нар мөн л хөтлөгч, тайлбарлагчаар тусдаа ажилласан. Үүнээс хойш тайлбарлагч телевизийн дэлгэцэнд өөрийн биеэр гарах шаардлагагүйгээр дүрсний цаана (закадр)-аас дуу хоолойгоороо тайлбарлан хүргэх болсон. 2010 оны дэлхийн аваргаар дөрвөн тайлбарлагч ажилласан бол бүтэн жилийн турш үргэлжилдэг Английн Премьер лигийг таван тайлбарлагч хүргэжээ.

Сүүлийн үед спортын контентийн үнэ өссөн нь телевизүүдийн өрсөлдөөнийг идэвхжүүлж,

шаардлагыг өндөрсгөх, мэргэшсэн сайн тайлбарлагчтай гэрээ байгуулах алхам болж байна. 2013-2014 оны Английн Премьер лигийг 2.1 тэрбум

төгрөгөөр авсан нь хөл бөмбөг сонирхогч олон байгааг бэлээхэн харуулж байна. Гэхдээ энэ үнийн хөөрөгдөл ирээдүйд сул тал авчирч магадгүй. Учир нь хэд хэдэн телевиз байгуулах мөнгөөр контент худалдаж авах нь цаашдаа контентийн үнийг хөөрөгдөж, телевизүүд үнийг нь дийлэхгүй байх магадлал үүсгэж байна. Ингэснээр спортын тайлбарлагчдын ажил ч давхар хумигдах аюултай. Бангладешийн спортын контент худалдан авалт үүний сонгодог жишээ болон

үлдсэн. 160 сая хүн амтай Бангладеш хэрэглэгч ихтэй учраас спортын контентүүд асар өндөр үнэ хүрдэг. Эрх зүйн орчин муутай нь үнийг бүр их хөөсрүүлдэг. Бангладешийн телевизийн холбоо энэ бүхнийг шийдэхийн тулд бүх телевизтэйгээ тохиролцоод Премьер лигийг авахгүй гээд тэндэрт оролцсонгүй. Гэтэл Премьер лигээс эрхийг авсан зуучлагч компани заавал нэвтрүүлэх үүрэг хүлээсэн учраас авсан үнээрээ өгөх гэж оролджээ. Сүүлдээ Америкийн "FOX" спортоор Бангладеш тайлбартайгаар

гаргаж Бангладешчүүд үнэгүй үзсэн юм. Энэ нь телевиз, зуучлагч компаниудад том сургамж өгсөн. Үүний дараагаар Бангладешт спортын

«

Сүүлийн үед спортын контентийн үнэ өссөн нь телевизүүдийн өрсөлдөөнийг идэвхжүүлж, шаардлагыг өндөрсгөх, мэргэшсэн сайн тайлбарлагчтай гэрээ байгуулах алхам болж байна. 2013-2014 оны Английн Премьер лигийг 2.1 тэрбум төгрөгөөр авсан нь хөл бөмбөг сонирхогч олон байгааг бэлээхэн харуулж байна. Гэхдээ энэ үнийн хөөрөгдөл ирээдүйд сул тал авчирч магадгүй. Учир нь хэд хэдэн телевиз байгуулах мөнгөөр контент худалдаж авах нь цаашдаа контентийн үнийг хөөрөгдөж, телевизүүд үнийг нь дийлэхгүй байх магадлал үүсгэж байна. Ингэснээр спортын тайлбарлагчдын ажил ч давхар хумигдах аюултай

»

контентийн үнэ буурч, тайлбарлагчдын ажил ундарсан.

Манайд 2014 онд үүнтэй төстэй үйл явдал болж телевизүүдийн холбоо Сочигийн өвлийн олимпийн эрхийг авахгүй байхаар аман тохиролцоонд хүрсэн боловч “ТВ5” телевиз амлалтаасаа буцаж эрхийг нь авсанаар контентийн үнийн өсөлтийг хязгаарлаж чадаагүй. Энэ нь дараа дараагийн тэмцээнд том чөдөр болсон юм.

2014 оны хөл бөмбөгийн дэлхийн аваргаар зургаан тайлбарлагч ажилласан нь манайд урд өмнө байгаагүй олон тайлбарлагчтай тэмцээний дамжуулалт болов.

Одоогийн байдлаар шууд дамжуулж байгаа хөл бөмбөгийн тэмцээнүүдийг 11 тайлбарлагч хүргэж байна. Дээр нь хөл бөмбөгийн тоглогчид тайлбарлагч аналитист хийх болсон нь тайлбарыг илүү мэргэшсэн түвшинд хүргэхэд чухал нөлөө үзүүлж байгаа юм. Хөл бөмбөгийн тоглогчдоос Б.Батзаяа, 2011 оны үндэсний лигийн мэргэн бууч Х.Амгалан, “Мазаалай” клубын тоглогч Д.Батцэнгэл нар тайлбарлагчаар ажиллаж байна. 2004 оны Афины олимпийн хөл бөмбөгийн төрлийг шигшээ багийн дасгалжуулагч И.Отгонбаяр, Л.Доржжав нар тайлбарлаж байлаа. Тоглогч, дасгалжуулагчид телевизийн салбарт ажилласнаар мэргэжлийн үг хэллэгийг зөв ашиглах давуу талтай болж байгааг тэмдэглэх хэрэгтэй.

Телевизийн спортын сэтгүүлчдийн тоо эрс өсч, тайлбарлагчийн мэдээлэл, үг хэллэг, илэрхийлэх чадвар сайжирч зарим талаар телевизийн соёл, тайлбарлагчийн ажил мэргэжлийн онцлогийг үл ойшоож зохисгүй авир гаргаж, ёс зүйн алдаа гаргаж байгаа нь спортын тайлбарыг хөгжүүлж

төрөлжүүлэх, түүнд зориулсан тусгай гарын авлага гаргах, тайлбарлагчдыг мэргэшүүлэх, телевизийн эфирийн соёлоос суралцуулах, спортын сурвалжлагч, тайлбарлагчийн сургалтыг чухалчлан үзэх зэрэг шаардлагыг бий болгож байна.

Ишлэл

¹Н.Озеров. Сурвалжлагаа сурвалжилсан минь. х.137.

²Ц.Галбадрах. Монголын цуут. УБ. 2014.

³Ж.Батбаатар, С.Амартүвшин, М.Одмандах. Практик сэтгүүл зүй. УБ. 2010. х.159.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Батбаатар Ж, АмартүвшинС, Одмандах М. 2010. Практик сэтгүүлзүй. УБ.
2. Батзаяа Б. 2010. Хөл бөмбөгийн дэлхийн аварга 1930-2010. УБ.
3. Галбадрах Ц. 2014.Монголын цуут. УБ.
4. Менчер М. 2002.Сэтгүүлзүйн бичлэгийн үндэс. УБ.
5. Озеров Н. 1980.Сурвалжилгаа сурвалжилсан минь. УБ.

Summary

This article discusses history of sports' explanation of Mongolia and sport's journalists' skills' issues. Sports' journalists in broadcasting system have been increasing rapidly and besides information, expressions, and annunciation abilities of columnists have developed till present. On the other hand, some columnists tend to be ignorant communication skills and principles of broadcasting system and professional features of columnists and reporters and behave inappropriately without ethics and morality. It means that there is necessity to develop sports review and classify it and publish special textbooks in order to specialize reporters and columnists, tutoring